

МОНГОЛ УЛС, ЯПОН УЛСЫН ХООРОНД ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООСОН НЬ

Б.СЭРЖАВ*

Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Япон улсын хооронд албан ёсны дипломат харилцаа тогтоох үйл явц нь бага бус хугацаа, хоёр талын ихээхэн хүчин чармайлтыг шаардаж, хэд хэдэн удаагийн тодорхой алхмуудыг дамжиж хэрэгжсэн нарийн төвөгтэй асуудал байсан юм. Хоёр орны хооронд албан ёсны харилцаа байгаагүй тухайн нөхцөлд хоёр тал янз бүрийн шугамаар холбоо харилцаа тогтоох тодорхой алхмуудыг хэрэгжүүлж байсан юм. Тухайлбал, 60-аад оны эхэн гэхэд хоёр орны хооронд худалдааны харилцаа нэгэнт тогтож, жилээс жилд өргөжсөөр байсан хийгээд хоёр улсын Гадаад явдлын Яамд, эрдэм шинжилгээний байгууллага, Найрамдлын нийгэмлэг, Улаан загалмайн нийгэмлэг зэрэг олон нийтийн байгууллагуудын шугамаар яриа хэлцэл хийж холбоо харилцаа тогтоож байлаа. Түүнчлэн хоёр улсын харилцааг хэвийн болгох санал санаачлагын тухайд л гэхэд 1956 оны аравдугаар сарын 19-нд Зөвлөлт, Японы хооронд дипломат харилцааг сэргээсэн үйл явдлыг Монгол Улс баяртайгаар хүлээн авч, 1957 онд БНМАУ-ын Засгийн газар өөрийн саналыг илэрхийлж байжээ. ЗСБНХУ, БНМАУ-ын хамтарсан албан мэдээнд: “БНМАУ-ын Засгийн газар ЗХУ, Япон улсын хооронд дипломат харилцааг сэргээн тогтоосон явдалд баяр хүргэж, хоёр орны хоорондын харилцааг хэвийн болгох асуудлаар Япон улсын Засгийн газартай хэлэлцээ хийхэд бэлэн байгаагаа илэрхийлж байна” хэмээн мэдэгдэж байсан зэрэг нь Монгол, Японы хооронд албан ёсны дипломат харилцаа тогтоох явдалд тус нэмэр болсон гэж үзэж болно.

Японы тал ч БНМАУ-тай дипломат харилцаа тогтоох саналыг 60-аад оны эхнээс эхлэн удаа дараа тавьж байв. Анх 1961 оны тавдугаар сарын 8-нд Варшав дахь Япон улсын хэргийг түр хамаарагч ноён Окада Монгол улсаас Польшид суугаа Элчин сайдын Яамны нэгдүгээр нарийн бичгийн дарга Санжмятавт “Манай хоёр орны хооронд албан ёсны харилцаа тогтоох ёстой, үүнд шийвэрлээд байх онц асуудал байхгүй”¹ хэмээн хэлжээ. Түүний дараа 1961 оны зургадугаар сарын 5-нд мөн Варшав дахь Японы хэргийг түр хамаарагч ноён Окада манай улсаас Польш улсад суугаа элчин сайд Бат-Очирт:

-Япон, Монголын харилцааны асуудлыг таньтай албан бусаар

* Б.Сэржав. ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, дэд профессор.

ярилцах гэсэн юм. Танайх Японтой дипломат харилцааг тогтоож дайны байдлыг устгах саналтай байна гэж би Засгийн газартаа тавьж болох уу. Харин дайны байдалтай холбогдуулан танайх Японы талд ямар шаардлага тавих вэ² хэмээн асууж байжээ.

Удалгүй 1961 оны зургадугаар сарын 23-нд Варшавт суугаа Япон улсын шинэ Элчин сайд Кавасаки, Монгол улсаас суугаа Элчин сайд Бат-Очирт хандан Япон улсын Засгийн газар БНМАУ-тай найрсаг харилцааг хөгжүүлэх бодлогын үүднээс төлөөлөгчөө Монгол улсад хоёр сарын хугацаагаар явуулах хүсэлтэй байгаагаа илэрхийлж, уг төлөөлөгчдийн томилолтын зорилго нь Монгол Улсын Засгийн газартай шууд холбоо тогтоох, хоёр ард түмний хоорондын харилцааг цаашид гүнзгийрүүлэх сонирхлын улмаас танай орны байдалтай танилцах явдал болно хэмээн тайлбарлаж, хэд хоногийн дараа болсон уулзалт дээр

-Хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоох асуудлыг Японы Засгийн газар юу гэж үздэгийг сонирхсон Элчин сайд Бат-очирт Япон улсын элчин сайд ноён Кавасаки

-Хоёр орны хооронд худалдааны харилцааг хөгжүүлэн, дипломат харилцаа тогтоох бодол бий. Монгол нь тусгаар тогтносон улс тул манай хоёр орны хооронд онцын бэрхшээл байхгүй³ хэмээн хариулжээ.

Ийнхүү Япон улсын зүгээс манай улстай дипломат харилцаа тогтоох асуудлыг тавьж, 1961 оны тав, зургадугаар сард Варшав хотноо дипломат шугамаар хэдэн удаа уулзалт ярилцлага явагдаж байсан ажээ.

Японы тал мөн саналаа дээрх үйл явдалтай нэгэн зэрэг Москвад суугаа манай улсын элчин сайдын яаманд хандан тавьсан байна. 1961 оны зургадугаар сарын 21-нд Москвад суугаа Японы хэргийг түр хамаарагч Акира Шигэмицү БНМАУ-аас Москвад суугаа Элчин сайд С.Лувсантай уулзаж Японы Засгийн газар хоёр орны хоорондын харилцааны асуудлыг сонирхож байна. Монголын Засгийн газар энэ асуудлыг хэрхэн үзэж байгаа тухай судлан сонирхох, мөн танай орны хөгжил байдалтай танилцахаар тус хоёр орны харилцааны анхны алхам болгож Японы төлөөлөгчөөр хоёр хүнийг Монголд очуулахыг хүсч байна гээд энэ асуудлаарх манай Засгийн газрын саналыг сонирхжээ.⁴

Дээрх саналын дагуу Япон улсын Засгийн газраас томилогдсон анхны элч Гаага дахь Японы ЭСЯ-ны гуравдугаар нарийн бичгийн дарга Мутто, Москва дахь Японы ЭСЯ-ны гуравдугаар нарийн бичгийн дарга Акихо нарын хоёр дипломат 1961 оны аравдугаар сарын 1-ний өдөр Улаанбаатарт ирж, 23 хоног ажиллаад аравдугаар сарын 23-нд

Москва руу буцсан байна. Мутоо, Акихо нар манай оронд байхдаа Улаанбаатар хотын байдал, манай орны эдийн засгийн бүтээн байгуулалт, Монгол улсын гадаад харилцаа зэрэг бүхий л талын ажиглалт судалгаа хийж, хөдөө явж үзсэн нь тэдний бичсэн тайлан илтгэлээс тодорхой байна. Хоёр нарийн бичгийн дарга тайландаа: “Ажлын хувцастай хятад ажилчид Улаанбаатар хотод газар сайгүй тааралдана. Тэд хотын орон сууц, зам гүүр зэрэг барилга байгууламж дээр ажиллаж байна. Хөдөө орон нутагт ч орон сууд барих, зам засвар, мод бэлтгэл, ачаа тээвэр зэрэгт ажиллаж буй хүмүүсийн ихэнх нь хятад ажилчид байна, монголчууд өөрсдөө тийм ажлыг хийдэггүй бололтой”⁵ гэхчлэн бичсэнийг Токио Их сургуулийн профессор Это Шинкичи хожим Монголд аялсан замын тэмдэглэлдээ иш татаж бичжээ. Мутоо, Акихо нар нь Монголд байх хугацаандаа Монгол экспортын дарга Цэрэнсанжаатай уулзаж хоёр орны хоорондын худалдааны асуудлаар, ГЯЯ-ны хэвлэлийн хэлтсийн дарга Эрдэмбилэгтэй уулзаж хоёр орны харилцааны асуудлаар ярилцжээ.⁶

Монгол Японы хооронд албан ёсны дипломат харилцаа тогтоох тухай 60-аад оны эхнээс ингэж ажил хэрэгчээр яригдсан боловч асуудал саадгүй шийдвэрлэгдэхэд удаан хугацаа шаардагдсан юм. Харилцаа хэвийн болоход дайны төлбөрийн асуудал гол саад болж байлаа.

Япон улс нь Сан Францискогийн Энхийн Гэрээний дагуу Японы арми дайн өдүүлж, эзлэн түрэмгийлсэн улс орнуудад дайны төлбөр төлөх үүргийг хүлээсэн юм. Япон улс 1955 оноос Бирмд 72 тэрбум иений дайны төлбөрийг төлж эхэлснээр Энхийн Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх анхны алхмаа хийж, 1976 оныг дуустал Зүүн өмнөд Азийн Бирм, Филиппин, Индонез, Өмнөд Вьетнамд нийт 364 тэрбум 340 сая иений төлбөрийг төлжээ. Түүнээс гадна дайны төлбөрийг эдийн засгийн хамтын ажиллагааны хэлбэрээр хэрэгжүүлж 1959-1977 онд Лаос, Камбож, Бирм, Өмнөд Солонгос, Малайз, Сингапур зэрэг улсад 166 тэрбум 780 сая иений эдийн засгийн хамтын ажиллагааг явуулжээ.⁷ Төлбөр нэхэмжлэгч орны санал хүсэлтийг судласны үндсэн дээр Японы Засгийн газар дайны төлбөр, эдийн засгийн хамтын ажиллагааг бэлэн мөнгөөр бус, харин Японы хувийн үйлдвэр, компаниудад бэлэн мөнгийг шилжүүлж, тэдгээр үйлдвэрүүд өөрийн бүтээгдэхүүн болон үйлчилгээг төлбөр хүлээн авагч орнуудад шилжүүлэх замаар төлбөрийг хийсэн нь ихээхэн онцлогтой болжээ. Өөрөөр хэлбэл дайны төлбөр, эдийн засгийн хамтын ажиллагаа нь японы бүтээгдэхүүний экспортыг үлэмжхэн хэмжээгээр өсгөж, эдийн засгийн хамтын ажиллагаа нь гүүр, далан зэрэг барилга байгууламж, цахилгаан бараа угсрах аж үйлдвэрийн газрууд, автомашин, хөлөг онгоц зэрэг хүнд үйлдвэрийн бүтээгдэхүүний

хэлбэрээр хэрэгжсэн нь Японы хүнд, химийн аж үйлдвэрийн хөгжилд ихээхэн түлхэц үзүүлжээ. Дайны төлбөр төлөх асуудлыг нэгд, тэдгээр орнуудтай харилцаагаа хэвийн болгох, хоёрт, өөрийн эдийн засгийн хөгжлийг урагш ахиулах, гуравт, төлбөр авагч орнуудтай худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааг тогтоон цаашид гүнзгийрүүлэхэд хамгийн оновчтой зөв ашиглаж чадсан ажээ.

Гадаад харилцааны яамны архивт хадгалагдан буй баримт материалаас үзэхэд хоёр орны харилцааг хэвийн болгох яриа хэлцээ 1965 оныг хүртэл түр завсарласан мэт харагдана. 1965 оны дөрөвдүгээр сарын эхээр Дугаржав тэргүүтэй манай улсын худалдааны төлөөлөгчдийг Японд очиход Японы ГЯЯ-ны Азийн газрын дарга Хара, орлогч дарга Камара, ажилтан Ханада нар хүлээн авч уулзахдаа

–Манай хоёр орны хооронд худалдааг улам өргөтгөх нь цаашид улс төрийн харилцаа тогтооход алхам болох ёстой. Улс төрийн харилцаа тогтоохын өмнө оюутан солилцох, соёлын төрөл бүрийн өргөн харилцаа тогтоож хүмүүсийг харилцан явуулж байх нь зүйтэй байна хэмээн санал бодлоо илэрхийлжээ.

1966 оны наймдугаар сард Японы Парламентын гишүүн Хасэгава Такэши тэргүүтэй 15 хүнтэй төлөөлөгчид Монгол улсад анх удаа айлчилсан нь цаашид харилцаа тогтооход чухал түлхэц болсон үйл явдал болжээ. Тэдгээр төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд хамт ирсэн Японы ГЯЯ-ны Дорнод Европын орнуудын товчооны орлогч дарга М.Акихо, ГЯЯ-ны дипломат М.Ханада нар Монгол улсын ГЯЯ-ны хоёрдугаар хэлтсийн дарга П.Цэрэнцоодолтой уулзаж хоёр орны хооронд хэвийн харилцаа тогтоох асуудлаар санал солилцож хэлэлцээ хийжээ. Энэ уулзалтаар хоёр орны хооронд ямар нэг асуудал байхгүй (дайны байдал байгаагүй, иймээс дайны төлбөрийн асуудал ч байхгүй) гэсэн үндсэн дээр дипломат харилцаа тогтооход Японы тал бэлэн байгаа юм гэлгийг мэдэгдсэн ба манай тал хоёр орны хооронд нэгэнт байгаа асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй юм гэсэн байр суурийг илэрхийлжээ. Цаашид энэ асуудлаар Москва дахь Элчин сайд нар ярилцаж болох юм гэж тохиролцжээ.⁸ Энэ уулзалт нь хоёр орны харилцааны асуудлаар Монгол, Японы ГЯЯ-дын албаны хүмүүс уулзаж Засгийн газрын байр сууриа тайлбарласан анхны хэлэлцээ байсан юм.

Парламентын гишүүн Т.Хасэгава тэргүүтэй уг төлөөлөгчид нь бас манай улсад байгаа Японы олзлогдсон цэргүүдийн булшийг эргэх зорилгоор ирсэн байв. 60-аад оны дунд үеэс олзлогдсон япон цэргүүдийн булшийг эргэх, төрөл төрөгсдийг нь Монгол улсад ирүүлэх хүсэлтийг Японы талаас олон удаа тавьж байсан юм. Түүхч, доктор Ц.Батбаярын бичсэнээс үзвэл 1945 оны арваннэг, арванхоёрдугаар

ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

сард японы цэргийн олзлогдогсад нийт 12318 хүнийг Зөвлөлтийн Алс Дорнодын цэргийн командлалаас Монголын засгийн газарт хүлээлгэн өгчээ. Тэдгээр цэргүүд Улаанбаатар, Сүхбаатар, Төв аймагт ихэвчлэн барилга дээр ажиллаж байжээ. Хоёр жилийн хугацаанд 1600 орчим хүн янз бүрийн шалтгаанаар голдуу өвчнөөр үхэж үрэгдсэн байна. Үлдсэн 10705 япон хүнийг Зөвлөлтийн талд 1947 оны аравдугаар сард эргүүлэн хүлээлгэж өгсөн байна.

1971 оны есдүгээр сард Монгол улсад ирсэн Японы Засгийн газрын сайн санааны төлөөлөгчдийн тэргүүн Накашима Монгол улсын ГЯЯ-ны сайд Ринчинтэй уулзаж ярилцахдаа “дэлхийн хоёрдугаар дайны дараа манай 13844 цэрэг энд ирсэн. Түүнээс Монголын талын судалгаагаар 1612 хүн, Японы талын судалгаагаар 1684 хүн энд нас барсан гэж сонссон. Эдгээр нас барагсдын дотроос 1566 нь 10 газарт булшлагдсан гэдгийг мэднэ”⁹ гэжээ.

Японы олзлогдсон цэргийн асуудал нь Монгол, Японы харилцааг хэвийн болгох асуудлын хүрээнд хоёр талын хооронд олон удаа яригдаж, Улаан загалмайн нийгэмлэгийн болон бусад шугамаар манай тал төрөл төрөгсдийг нь ирүүлэх, булшийг хамгаалж арчлах зэрэг арга хэмжээг авчээ.

Хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоох тухай асуудлыг 1967 оны үеэс эхлэн Москвад суугаа Элчин сайд нарын хэмжээнд нэлээд идэвхтэй шаргуу хэлэлцэж эхэлсэн нь архивт байгаа баримт материалуудаас тодорхой харагдана.

1967 оны зургадугаар сарын 5-нд Япон улсаас ЗХУ-д суугаа Элчин сайд Т.Накагава БНМАУ-ын Элчин сайд Н.Лувсанчүлтэмтэй уулзаж “Японы Засгийн газар хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоох хүсэлтэй байна. Тэгэхдээ хоёр орны хооронд хожим сүүлд эвгүй зүйл үлдээхгүйг эрмэлзэж байна. Иймээс харилцаа тогтоох тухай солилцох нотлоо хоёр орны хооронд шийдвэрлэгдээгүй асуудал байхгүй гэж дурдах саналтай байна. Японы тал тус хоёр орны хооронд дайны төлбөрийн асуудал байхгүй гэж үзэж байна. Харин танай Засгийн газар тийм асуудал бий гэж үзэх бол энэ нь цаашдаа төвөгтэй л асуудал болох байх. Дээрх нь Японы Засгийн газар хоёр орны хооронд найрамдлын үндсэн дээр найрсаг харилцаа тогтооё гэсэн эрмэлзлэл дүүрэн байгаатай холбоотой юм. Иймд манай саналыг харгалзахыг танай Засгийн газарт хүсч байна” гэж Японы талын саналыг мэдэгджээ.¹⁰

1967 оны есдүгээр сарын 21-нд Москвад суугаа элчин сайд Н.Лувсанчүлтэм Японы элчин сайд Т.Накагава-тай уулзаж, өнгөрсөн зургадугаар сарын 5-нд Япон Монголын харилцааны талаар тавьсан

түүний саналд хариу болгож манай талын саналыг мэдэгджээ. Үүнд:

-Монгол, Японы хооронд дипломат харилцаа тогтоох асуудлыг манай хоёр орны харилцааны шийдвэрлэгдээгүй байгаа зарим асуудал, тухайлбал дайны төлбөрийн асуудалтай заавал нэгэн зэрэг шийдвэрлэнэ гэж хойшлуулах хэрэггүй юм гэж үзэж байсан манай бодлого хэвээр байна. Харин ёс төдий дайны байдалтай байгаа явдлыг юуны урьд эцэс болгон арилгаж, дипломат харилцаа тогтоогоод дайны төлбөрийн тухай асуудлыг байгаа туршлагыг харгалзан харилцан ойлголцох үндсэн дээр зохистойгоор шийдвэрлэж болох юм гэж үзэж байна гээд дайны төлбөрийн асуудлын тухайд хоёр орны эрх ашгийн үүднээс шийдвэрлэх ёстой. Гэхдээ уг асуудлыг төлбөр, тусламж гэх мэт ямар нэгэн нэр томъёо хэрэглэхгүйгээр, шуугиан дэгдээлгүйгээр, хоёр талд тохиромжтой ямар нэг хэлбэрээр зохицуулан хэрэгжүүлж болох юм гэсэн санаагаар тайлбарласан байдаг.

Дээрх саналын хариу болгож ноён Т.Накагава Японы Засгийн газар Монгол улстай дипломат харилцаа тогтоохыг хүсч байна. Харин Японы Засгийн газар Япон Монголын хооронд дайны төлбөрийн асуудал байхгүй гэж үзэж байгаа болохоор энэ талаар хоёр талын санал ялгаатай, зөрөөтэй байна. Хоёр орны хооронд харилцаа тогтооход манай тал бэлэн байгаа гэж бодож байна. Нөгөө талаар дайны төлбөрийг шийдвэрлэх арга замын талаар таны ярьсан зарим санаа бидэнд сонирхолтой байна. Жишээлэхэд, монголын сонирхож байгаа аль нэг эдийн засгийн салбарт Японоос мэргэжилтэн явуулж ажиллуулж болох юм гэж хэлэх байна. Дипломат харилцаа тогтоосны дараа Японы Засгийн газар Монголтой дайны төлбөрийн хэлбэрээр бус, харин эдийн засгийн чин үнэнч хамтын ажиллагааг хөгжүүлэх хүсэлтэй байгаа юм¹¹ гэжээ.

1968 оны хоёрдугаар сард Япон Монголын найрамдлын нийгэмлэгийг зохион байгуулах хуралд оролцохоор Японд хүрэлцэн ирсэн Монголын ЭТНБХ-ны Гүйцэтгэх Хорооны дарга Д.Адилбишийг Японы эрх баригч Либерал Ардчилсан намын суртал ухуулгын ажлыг эрхэлсэн дарга, Парламентын гишүүн Хасэгава (1966 оны наймдугаар сард олзлогдсон цэргүүдийн булш эргэхээр Монголд ирсэн Японы төлөөлөгчдийн тэргүүн) хүлээн авч уулзаж хоёр орны харилцааг хэвийн болгох асуудлаар ярилцсан байна. Тэрээр ярихдаа

-Танай улсыг НҮБ-д элсэхэд Япон улс дэмжиж байсан. ...Дайны төлбөрт 80 сая доллар Япон улс төлнө гэхэд маш хүнд шүү дээ. Үүнээс болоод манай хоёр орны хооронд хэвийн харилцаа тогтоож чадахгүй байгаа юм. Харин дайны төлбөр гэхгүйгээр эдийн засгийн янз бүрийн хэлбэрээр Япон улс танайд тусалж болох юм. Жишээлэхэд хөнгөлөлттэй зээл олгох, хамтын хүчээр үйлдвэр завод барих, янз бүрийн салбарын

мэргэжлийн хүмүүс явуулж танай ажилд туслах, танай оюутан сурагчид, дадлага хийх хүмүүсийг үнэ төлбөргүй сургаж өгөх, танайд Япон улс экспортынхоо барааг хямдруулан худалдаж үнийг аажимд нөхөх гэх мэт янз бүрийн хэлбэр байж болох юм гэжээ.

1969 оны дөрөв, зургаа, наймдугаар саруудад Москвад суугаа БНМАУ-ын Элчин сайд Н.Лувсанчүлтэм, Япон улсын элчин сайд Т.Накагава нар хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоох асуудлаар хэд хэдэн удаа уулзаж ярилцжээ. Япон улсын Засгийн газар БНМАУ-тай дипломат харилцаа тогтоох саналтай байгаагаа дахин албан ёсоор илэрхийлж, Элчин сайд Т.Накагава хэлэхдээ: “Японы Засгийн газар БНМАУ-тай дипломат харилцаа тогтоох хүсэлтэй байна. Тэгэхдээ тус хоёр орны хооронд дайны байдал байгаагүй учир уг асуудлыг хөндөхгүй байх, иймээс дайны төлбөр буюу түүнийг орлож болох эдийн засгийн хамтын ажиллагааны асуудал байж болохгүй гэсэн үндсэн дээр ярилцах нь зүйтэй гэж үзэж байна. Японы талын хүлээн авч болохуйц эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны талаар Монголын талын саналыг сонсоход бэлэн байна. Дээрх нөхцөлийг Монголын тал хүлээн авбал Япон улс Монголтой дипломат харилцаа тогтооход бэлэн байна гэжээ.

1969 оны зургадугаар сарын 16-ны өдөр Элчин сайд Н.Лувсанчүлтэм Японы Элчин сайд Т.Накагаватай уулзаж Японы Засгийн газрын дээрх саналд хариу өгсөн байна. Үүнд:

-Монгол, Японы хооронд дайны байдал байгаагүй гэдэг нь бодит байдалд нийцэхгүй байна. Дайнаас учирсан хохирлын тухай асуудлыг манай улс Японы талд тавих бүрэн эрхтэй. Гэвч танай Засгийн газрын саналыг харгалзан үзэх үндсэн дээр хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоох асуудлаар хоёр Засгийн газрын эрх бүхий төлөөлөгчид ойрын үед уулзан ярилцаж болох юм гэж манай Засгийн газар үзэж байна¹² гэжээ.

Манай улсын энэ саналыг Японы тал нарийн судалж үзсэн нь мэдээж юм. 1969 оны наймдугаар сарын 20-нд Элчин сайд Т.Накагава Монгол Улсын элчин сайд Н.Лувсанчүлтэмтэй уулзаж “Японы тал Монгол улсын нэгэн адил хоёр орны хооронд найрсаг харилцааг аль болох түргэн хугацаанд тогтоохыг эрмэлзэж байна. Танай манай баримталж байгаа бодлого нэлээд ойролцоо болсон боловч санал нийлэхгүй зүйл байна. Япон Монголын хооронд дайны байдал байгаагүй гэдэг бодлогоо Японы тал хэвээр баримталж байна. Үүнээс үндэслэн манай хоёр орны хооронд дайны төлбөрийн асуудал байж болохгүй гэж Японы тал үзэж байна. Монгол улсыг Япон улс албан ёсоор хүлээн зөвшөөрсөн гэж манай Засгийн газар үздэг. Одоогоор манай хоёр улсын хооронд

дипломат харилцаа тогтоогүй авч эдийн засаг, техникийн талаар дипломат харилцаатай орны нэгэн адил харилцаатай байхыг хүсээд зогсохгүй харилцаагаа цаашид хөгжүүлэх эрмэлзлэлтэй байна.

Мөн манай Засгийн газар Монголтой НҮБ-ын хэмжээнд болон зэвсэг хураах хороонд хамтран ажиллах хүсэлтэй байна гэдгийг Засгийн газрынхаа даалгавраар мэдэгдэж байна”¹³ гэжээ.

1969 оны долдугаар сарын 10-16-нд Японы нам, Парламентын гишүүдийн хэсэг манай оронд айлчилж, Монгол ардын хувьсгалын 48 жилийн ойд оролцсон нь хоёр орны хооронд дипломат харилцаа тогтооход тодорхой түлхэц үзүүлсэн юм. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Японы Парламентын гишүүд Либерал Ардчилсан Намаас сонгогдсон Ямагучи Тошио, Кацураги Тэцүо, Комэй намаас сонгогдсон Хиросава Наоки, Социалист намаас сонгогдсон Ига Саламори, Чига Ёшио Ардчилсан Социалист намаас сонгогдсон Ёшида Юкихиса, монголч эрдэмтэн Танака Кацухико нар оролцжээ.¹⁴ Төлөөлөгчдийг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга Ю.Цэдэнбал долдугаар сарын 13-нд өөрсдийнх нь хүсэлтээр хүлээн авч уулзан хоёр орны харилцааны асуудлаар санал солилцжээ. Энэ уулзалт дээр Ю.Цэдэнбал: “Хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоох нь чухал гэж бид үзэж байна. Ийм харилцаа тогтооход Монголын Засгийн газар бэлэн байна. Японы олон нийтийн зүтгэлтэн, сонин газрын төлөөлөгчид энэ тухай манай саналыг нэг бус удаа асуусан. Харилцан бие биеэ хүндэтгэх, эрх тэгш байх, нэг нэгийгхээ дотоод хэрэгт үл оролцох зарчмын үндсэн дээр Японтой дипломат харилцаа тогтооход манай Засгийн газар бэлэн байна.

...Дайны төлбөрийн асуудлыг дипломат харилцаа тогтоосоны дараа шийдвэрлэж болох юм. Шийдвэрлэх ч хэрэгтэй юм” хэмээн мэдэгджээ.

Парламентын гишүүдийн Монгол улсад хийсэн энэ айлчлалын талаар Японы хэвлэл, мэдээллийн хэрэгслээр өргөн мэдээлж байв. Энэ айлчлал Японы ард түмний дунд манай улстай дипломат харилцаа тогтоох идэвхийг өргөжүүлж, манай улсын нэр хүнд олон улсын тавцанд дээшлэхэд чухал нөлөө үзүүлсэн юм.

Парламентын гишүүд нутагтаа очоод Ерөнхий сайд Саго, ГЯА-ны сайд Айичи нартай уулзан айлчлалын үр дүнгээ илтгэсэн бөгөөд 1972 онд Монгол Японы хооронд дипломат харилцаа тогтооход эдгээр гишүүдийн хүчин зүтгэл, идэвхтэй оролцоо ихээхэн тус дөхөм болсон билээ.

1970 оны наймдугаар сард БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга Д.Гомбожав тэргүүтэй Монгол улсын Засгийн газрын төлөөлөгчид Японы Засгийн газрын урилгаар Япон улсад айлчилж

дэлхийн ЭКСПО-70 үзэсгэлэнд оролцсон билээ. Төлөөлөгчид наймдугаар сарын 15-нд Японы ГЯЯ-ны сайд Айичи хүлээн авч уулзан хоёр орны харилцааг хөгжүүлэх хүсэлтэй байгаагаа илэрхийлж “Би ч мөн хоёр орны харилцааг хөгжүүлэх асуудлыг сонирхож байна. Хүмүүсийг солилцох, эдийн засаг, соёлын хамтын ажиллагааг хөгжүүлэх нь чухал юм. БНМАУ, Японы харилцааг хэвийн болгох явдалд зөвхөн дайны төлбөрийн асуудал саад болж байна”¹⁵ гэжээ. Монголын төлөөлөгчдийн тэргүүн Д.Гомбожав дайны төлбөрийн асуудлыг харилцааг хэвийн болгох асуудалтай холбож ярих шаардлагагүй гэж үзэж буй тухайгаа өгүүлээд дайны төлбөрийн асуудлыг дипломат харилцаа тогтоосны дараа ямар нэгэн хэлбэрээр шийдэж болно хэмээн саналаа илэрхийлжээ.

Дээрх айлчлалын хариуд манай Засгийн газар Японы Засгийн газар, Парламент, олон нийтийн нөлөө бүхий хүмүүсийг оролцуулсан Япон улсын Засгийн газрын сайн санааны төлөөлөгчдийг албан ёсоор урьсан юм. Энэ урилгыг японы тал талархан хүлээн авч, 1971 оны долдугаар сарын 29-нд Япон улсын Засгийн газрын албан ёсны төлөөлөгчид энэ онд Монголд айлчлал хийх гэж байгаа тухай Киодо Цүшин агентлаг мэдээлсэн юм.

1971 оны есдүгээр сарын 10-15-нд Японы Парламентын зөвлөхүүдийн танхимын гишүүн, Парламент дахь Либерал Ардчилсан Намын бүлгийн ахлагч Накашима Шигэки тэргүүтэй Япон улсын Засгийн газрын сайн санааны төлөөлөгчид Монгол улсад анх удаа албан ёсоор айлчилсан юм.¹⁶ Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Японы ГЯЯ-ны Азийн хэлтсийн ажилтан Сакияма Кисабуро, ГЯЯ-ны Азийн хэлтсийн зөвлөх Накаэ Ёосүкэ, Гонконгод суугаа Япон улсын Ерөнхий консулын газрын ажилтан Ханада Марохито, Москвад суугаа Японы ЭСЯ-ны нэгдүгээр нарийн бичгийн дарга Нишида Кацужо нар оролцжээ. Төлөөлөгчдийг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн нэгдүгээр орлогч дарга С.Лувсан, ГЯЯ-ны сайд Ринчин нар хүлээн авч уулзан хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоох асуудлаар санал солилцжээ. Энэ айлчлал монгол, японы харилцааг хэвийн болгох, яриа хэлэлцээг урагшлуулахад чухал алхам болсон юм. БНМАУ-ын ГЯЯ-ны сайд Ринчин хоёр орны харилцааг хэвийн болгох талаар манай улсын баримталж ирсэн байр суурийг тайлбарлаж, “Монгол Япон улсын харилцааг хэвийн болгох, хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоох асуудлаар манай Засгийн газар өөрийн баримталж байдаг чиг шугамыг аль 50-аад оноос эхлэн танай талд мэдэгдэж байсан билээ.

БНМАУ-ын Засгийн газар, Монгол Японы хооронд хэвийн

харилцаа, дипломат харилцаа тогтооход саад болох ямар нэг асуудал байхгүй гэж үздэг.

Монгол, Япон хоёр нь хэдийгээр нийгмийн өөр өөр байгуулалтай ч гэсэн энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын үндсэн дээр хоёр орны хооронд хэвийн харилцаа тогтоож болох юм. Манай хоёр орны хооронд хэвийн харилцаа тогтоох нь хоёр орны ард түмний эрх ашигт нийцэхээр барахгүй Ази болон даян дэлхийн энх тайвныг бэхжүүлэх хэрэгт тус нэмэр болох юм гэж бодож байна. Японы Засгийн газар мөн ийм хүсэл эрмэлзлэлтэй байгаа байх гэж үзэж байна.

Хэрэв хоёр орны хооронд хэвийн харилцаа, дипломат харилцаа тогтвол бусад салбарын харилцаа өргөжих юм. Одоо манай хоёр орны хооронд худалдааны харилцаа байгаа боловч дипломат харилцаа тогтоовол цаашдаа бүх талын харилцаа өргөжих болов уу гэж бодож байна.

Дипломат харилцаа тогтоох асуудлыг аль болох ойрын хугацаанд шийдвэрлэвэл хоёр орны ард түмний эрх ашигт нийцэх юм гэж үзэж байна.

...Бидний бодож байгаагаар хоёр орны хооронд хэвийн харилцаа, дипломат харилцаа тогтооход дайны төлбөрийн асуудал саад болох ёсгүй гэж үзэж байна.

Энэ нь хоёр өөр асуудал юм. Дайны төлбөрийн асуудлыг бид болж өнгөрсөн зүйлийг зөв зохицуулан шийдвэрлэх асуудал гэж үзэж байна. Дипломат харилцаа тогтоох нь хоёр орны харилцааг цаашид хэвийн болгож өргөтгөх асуудал гэж үзэж байна. Иймээс дайны төлбөрийн тухай асуудлыг хоёр орны хоорондын харилцаанд ямар нэгэн болзол болгон ярих нь хэрэггүй юм шиг бидэнд бодогдоно.

Хэрэв манай хоёр орны хооронд хэвийн харилцаа тогтоож дипломат харилцаатай болбол тэрхүү дайны өр төлбөрийн тухай асуудлыг зохих хэлбэрээр хоёр тал тохиролцож болох юм¹⁷ хэмээн тайлбарласан юм.

Японы Засгийн газрын сайн санааны төлөөлөгчид манай оронд байхдаа Улаанбаатар, Дархан хотод үйлдвэр, соёл, боловсролын байгууллага, түүх дурсгалын газрууд, манай улсын хөдөө аж ахуйн байдалтай танилцаж, Улаанбаатарт хэвлэлийн бага хурал хийлгэсэн юм. Төлөөлөгчдийн айлчлалын тухай товч мэдээ “Үнэн” сонины есдүгээр сарын 11, 12, 14, 15-ны дугааруудад нийтлэгджээ.

Монгол улсын ГЯЯ-ны хэлтсийн дарга П.Цэрэнцоодол, Гадаад худалдааны Яамны ажилтан Ц.Галсанжав нар 1971 оны арваннэгдүгээр сарын 5-13-нд Японы ГЯЯ-ны урилгаар Япон улсад айлчилжээ. Тэд Японы ГЯЯ-ны орлогч сайд Хогэн, Азийн газрын дарга Сүнобэ нар

болон Японы Парламентын гишүүд Э.Танака, К.Шоожи, Х.Ямада, Икэда, Ёшида нарын зэрэг улс төрчидтэй уулзаж ярилцжээ. Тэдгээр нөлөө бүхий улс төрчид монголын төлөөлөгчидтэй байдлыг ярилцаад Монголтой дипломат харилцаа тогтоох талаар манай Засгийн газраас нааштай шийдвэр гаргахад нөлөөлнө¹⁸ гэдгээ хэлсэн байна. Үнэхээр тэд Ерөнхий сайд Сато-тай уулзаж Японы Засгийн газрын шийдвэрийг яаравчлуулсан юм.

Японы Гадаад Яамны ажилтан Сакияма Кисабуро манай улсын төлөөлөгчдийг үдэж өгөхдөө арваннэгдүгээр сарын 13-ны өдрийн “Емиүри”, “Токио шинбүн” хоёр сонинг П.Цэрэнцоололд өгсөн байна.

Тэдгээр сонинд Япон монголын харилцааны талаар Японы Засгийн газрын хандлагыг илэрхийлсэн өгүүллийг нийтэлсэн байжээ. “Емиүри” сонинд “Монголтой дипломат харилцаа тогтоох Засгийн газрын үнэн бодол” гарчигтай өгүүлэлд “Японы Засгийн газрын тэргүүн, БНМАУ-ын Засгийн газартай дипломат харилцааг албан ёсоор тогтоох талаар нааштай шийдвэр гаргах гэж байгаагаар арваннэгдүгээр сарын 11-ний өдөр тодорхой болгов. ГЯЯ-ны үзэж байгаа нь Япон улс Монгол улстай дипломат харилцаа тогтооход ямар нэгэн саад тогтор нэгэнт үгүй, гагцхүү чухам хэдийд тогтоох вэ гэдэг хугацааг улс төрийн талаар бодож шийдвэрлэх асуудал үлдээд байна”¹⁹ гэжээ.

Мөн “Токио шинбүн” сонинд “Монголтой дипломат харилцаа тогтоох тийш” гэсэн гарчигтай өгүүлэлд “Хоёр саад арилав”, “ГЯЯ-ны албан тушаалтны шийдвэр”, “Цаашдын зорилгоо тодорхойлов” гэсэн давхар гарчигуудтайгаар “Япон ба БНМАУ-ын дипломат харилцаа тогтоох асуудлыг нааштайгаар авч хэлэлцэв гэсэн санааг ГЯЯ-ны албан тушаалтан 11-р сарын 12-нд тодорхойлов...”

Монгол, Японы хооронд дипломат харилцаа тогтооход Тайвань ба БНХАУ-ын асуудал саад болж байсан юм. Тайвань НҮБ-аас хөөгдөж, Монгол улс БНХАУ хоёр Элчин сайдаа солилцож харилцаа нь сайжрах төлөвтэй болов. Ийм учраас Монголтой дипломат харилцаа тогтооход урьд тохиолдож байсан саад тогтор арилах тийшээ хандаж Монголтой дипломат харилцаа тогтоох нөхцөл бүрэлдэв гэсэн дүгнэлтийг Японы ГЯЯ-ны албан тушаалтан нар баталгааж байна”²⁰ гэжээ.

Японы Засгийн газар тухайн үед БНХАУ-тай дипломат харилцаа тогтоох явдалд гол анхаарлаа хандуулж байсан бөгөөд 70-аад оны эхэн үед Хятад Америкийн харилцаа түргэн хурдацтайгаар сайжирч, АНУ-ын ерөнхийлөгч Никсон БНХАУ-д айлчилсан, БНМАУ-БНХАУ-ын харилцаанд нааштай хандлагууд гарч эхэлсэн. ЗХУ-ын ГЯЯ-ны сайд А.А.Громыко 1972 оны эхээр Япон улсад албан ёсны айлчлалт хийсэн.

зэрэг улс төрийн үйл явдлууд болон Монгол улстай албан ёсны дипломат харилцаа тогтооход Ерөнхий сайд Сато-д нөлөөлж чадсан Японы нөлөө бүхий улс төрчдийн үйл ажиллагаа нь Японы Засгийн газрын бодлыг өөрчилж БНМАУ-аас өмнө Монгол улстай дипломат харилцаа тогтооход хүргэсэн ажээ.

Москвэд суугаа Монгол улсын Элчин сайд Н.Лувсанчүлтэм, Япон улсын элчин сайд Нийзэки нар хоёр Засгийн газрыг төлөөлөн хэлэлцээ хийж, Японы тал дайны төлбөр гэдэг нэрээр бус, хамтын ажиллагааны хэлбэрээр Монголд зохих хэмжээний хөрөнгө өгөхийг мэдэгдсэн юм. Хоёр тал уг хэлэлцээгээр тохиролцоонд хүрч Япон улстай дайны байдлыг таслан зогсоох тухай МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны нууц тогтоол, БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлиг 1972 оны хоёрдугаар сарын 11-нд гарчээ. Энэ тухай “Ардын төр” сэтгүүлд Дайны байдлыг таслан зогсоов” гарчигтай мэдээнд нийтэлснээр “Монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолд байнга заналхийлж, БНМАУ-д удаа дараа халдан довтолж байсан Японы түрэмгийлэгчдийг бут ниргэх, Алс Дорнодод энх тайван байдал тогтоох ариун үйл хэрэгт тус дөхөм үзүүлэх эрхэм зорилгоор БНМАУ-аас милитарист Япон улсад шударга дайн зарласан тухай тунхаг бичгийг БНМАУ-ын Бага Хурал, Сайд нарын Зөвлөлөөс 1945 оны наймдугаар сарын 10-нд гаргасан билээ.

Нийгэм-улс төрийн өөр байгууламж бүхий улс гүрэнтэй энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын үндсэн дээр найрсаг харилцаа тогтоон хөгжүүлэхэд чиглэсэн БНМАУ-ын гадаад бодлогын чиг шугамыг удирдлага болгон БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1972 оны хоёрдугаар сарын 11-ний өдрийн зарлигаар БНМАУ, Япон улсын хооронд байсан дайны байдлыг таслан зогсоов”²¹ гэжээ.

Ингээд хоёр тал БНМАУ, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоосон тухай албан мэдээг хоёрдугаар сарын 19-нд Москвагийн цагаар өглөө 9 цагт нэгэн зэрэг албан ёсоор зарлан, хэвлэлд нийлэхээр тогтсон билээ.

“Үнэн” сонинд нийтлэгдсэн “БНМАУ, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоосон тухай хамтарсан албан мэдээ”-нд “БНМАУ, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоож, Элчин сайдын хэмжээнд дипломат төлөөлөгчид солилцохоор БНМАУ-ын Засгийн газар, Япон улсын Засгийн газар шийдвэрлэв.

БНМАУ, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоосон нь хоёр орны эдийн засаг, соёлын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлнэ гэдэгт итгэж байгаагаа хоёр тал илэрхийлэв”²² гэжээ.

Энэ хамтарсан албан мэдээ Японд Дейли “Емиүри” (1972.2.22.), “Майничи” (1922.2.23), “Санкэй шинбүн” (1972.2.19) сонинуудад нийтлэгджээ.

БНМАУ, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоосноо нотолж БНМАУ-аас Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Н.Лувсанчүлтэм, Япон улсын Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд К.Нийзэки нарын нот солилцох ёслол 1972 оны хоёрдугаар сарын 24-ний өдрийн 11 цагт Москва хотноо Япон улсын Элчин сайдын Яаман дээр болжээ. Энэ ёслолд манай талаас Москвад суугаа ЭСЯ-ны зөвлөх Б.Дашцэрэн, нэгдүгээр нарийн бичгийн дарга Ч.Хунжав, атташе Б.Нацагдорж, МОНЦАМЭ-гийн сурвалжлагч Э.Түмэнжаргал нар Японы талаас элчин зөвхөн Т.Хасэгава, зөвлөх К.Чиба, нэгдүгээр нарийн бичгийн дарга К.Нишида, атташе Х.Үэда нар байлшжээ. Ёслол дээр японы сурвалжлагч гэрэл зурагчин, кино оператор 20 шахам хүн байв. Энэ өдрийг хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосон өдөр гэж тооцохоор тогтжээ.²³ Ийнхүү Монгол, Япон хоёр улсын дипломатчдын нөр их зүтгэл хөдөлмөрийн үр дүнд хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтсон түүхтэй. Монгол, Японы хооронд дипломат харилцаа тогтож, хоёр орны харилцаа хэвийн болсон нь монгол японы ард түмний эрх ашигт бүрнээ нийцэж, хоёр орны бүх талын харилцаа, хамтын ажиллагаа өргөжин гүнзгийрэх сайхан боломжийг нээж өгсөн юм.

Хоёр тал эхний удаад Москвад суугаа Элчин сайд нараа хавсран ажиллах Элчин сайдаар томилохоор тогтож, манай Элчин сайд Н.Лувсанчүлтэм 1972 оны зургадугаар сард Японы эзэн хаанд итгэмжлэх жуух бичгээ гардуулж, Японы элчин сайд К.Нийзэки 1972 оны наймдугаар сард БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн даргад итгэмжлэх жуух бичгээ барьснаар хоёр орны харилцааны цоо шинэ үе эхэлсэн юм.

ИШЛЭЛ, ЗҮҮЛГ

1. Монгол улсын Гадаад харилцааны Яамны архив .Ф-59, Хн-63.
2. Монгол улсын Гадаад харилцааны Яамны архив .Ф-59, хн-63.
3. Монгол улсын Гадаад харилцааны Яамны архив .Ф-59, хн-63.
4. Монгол улсын Гадаад харилцааны Яамны архив .Ф-59, хн-63.
5. Асахи сонин, 1964.11.17.Это Шинкичи “Монголд аялсан тэмдэглэл”
6. Монгол улсын Гадаад харилцааны Яамны архив .Ф-59, хн-63.
7. Нихон-ши В (Японы түүх В), Токио шёсэки, 2000, 249-р тал
8. Монгол улсын Гадаад харилцааны Яамны архив .Ф-59, хн-63.
9. Монгол улсын Гадаад харилцааны Яамны архив .Ф-59, хн-63.
10. Монгол улсын Гадаад харилцааны Яамны архив .Ф-59, хн-63.
11. Монгол улсын Гадаад харилцааны Яамны архив .Ф-59, хн-63.
12. Монгол улсын Гадаад харилцааны Яамны архив .Ф-59, хн-63.
13. Монгол улсын Гадаад харилцааны Яамны архив .Ф-59, хн-55.
14. Монгол улсын Гадаад харилцааны Яамны архив .Ф-59, хн-63.
15. Монгол улсын Гадаад харилцааны Яамны архив .Ф-59, хн-63.
16. Үнэн. 1971.9.11.
17. Монгол улсын Гадаад харилцааны Яамны архив .Ф-59, хн-63.
18. Монгол улсын Гадаад харилцааны Яамны архив .Ф-59, хн-63.
19. Ёмиүри сонины 1971.11.13.
20. Токио шинбүн, 1971.11.13.
21. “Ардын төр” сэтгүүл .1972. №1.
22. “Үнэн” сонин. 1972.2.19.
23. Монгол улсын Гадаад харилцааны Яамны архив .Ф-59, хн-66.